



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/159

Мандалговь

“Ашид бьюолдинг” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/185 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Адаацаг сумын сургуулийн сантехникийн засварын ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюолдинг” ХХК-тай 59,521,063 (тавин есөн сая таван зуун хорин нэгэн мянга жаран гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Адаацаг сумын сургуулийн сантехникийн засварын ажил”-ыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюолдинг” ХХК-ний захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Адаацаг сумын Засаг дарга (Ч.Уранчимэг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 
Л.ДОРЖБАТ

488216786